

**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
“ХОТЫН СОЁЛ” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2021 оны 08 дугаар сарын 25

Багануур дүүрэг

1. Байгууллагын соёл, албан хаагчдын ёс зүйн хандлага, харилцааны соёлыг төлөвшүүлэх чиглэлээр дотооддоо сургалт зохион байгуулах, иргэдэд үзүүлж буй үйлчилгээндээ чирэгдэлгүй түргэн шуурхай байх

08 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүл амьдралын зөв дадал хэвшил” сургалтыг нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан. Сургалтаар дараах 3 дэд сэдвийг хэлэлцэн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Үүнд:

- Биологийн идэвхт цаг, зөв хооллохын ач тус
- Эрүүл амьдралын гол үндэс - дасгал хөдөлгөөний тухай
- Идэвхтэй амьдралыг бий болгох гол хүчин зүйлс

Хөрөнгө оруулагчид, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг цахимаар хүлээн авч, шаардлагатай мэдээ, мэдээллийг өдөрт нь, судалгааны чиглэлийн мэдээ мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан шуурхай хүргэн ажилладаг.

Байгууллагын албан хаагчид Соёлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган соёлын талаарх иргэний үүргээ биелүүлэн ажиллаж байна.

2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газраас бэлтгэсэн соён гэгээрүүлэх нөлөөллийн контент, нэвтрүүлэг, зурагт хуудсыг байгууллагын олон нийтийн сүлжээний цахим хуудас болон албан хаагчдын хувийн фейсбүүк хуудсаар дамжуулан сурталчлах, давлагаалуулах ажлыг зохион байгуулах

Нийслэлийн Соёл, урлагийн газар фейсбүүк хуудсанд тавигдсан “Соёлтой хотод хамтдаа амьдарцааа”, Улаанбаатар хотын музей олон нийтэд зориулсан үйл ажиллагаагаа цахимаар зохион байгуулж байгаа талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж байна. Цахим хуудаснаас мэдээллийг уншсан тоо - 34

The screenshot shows a web page with the following sections:

- Соёлтой хотыг бий болгоэ.** (Call to action button: Дэлгэрэнгүй...)
- Хувийн соён – Нийтийн соён**
Нийтийн соёлоос Хотын соён
Соёлтой хотыг бий болгоэ.
- Соёлтой болгоэ** (Call to action button: Дэлгэрэнгүй...)
- УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА**
- Паркад байгуулагдах үйлдвэрлэлийн бүсүүд**
 - Хүнсний үйлдвэрлэлийн бүс
 - Хөнгөн үйлдвэрлэлийн бүс
 - Хунд үйлдвэрлэлийн бүс
 - Ургамал, нанобиотехнологийн үйлдвэрлэлийн бүс
- Бидэнд санал болгох төсөл, ажил үйлчилгээ**
 - Иргэн хувь хүн
 - Аж ахуйн чагж байгууллага
- Албан тушаалтын ХОМ** (Video player showing a person speaking, with social media sharing icons: f, t, m, a).

Монгол улсад Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Соёл, урлагаар дамжуулан ёсвөр үе, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяас чадварыг нээн илрүүлж дэмжин урамшуулах зорилгоор зохион байгуулж буй "UB COVER 2021" ковер дууны мэдээллийг албан хаагчдын хувийн фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэн ажиллаж байна. Мэдээллийг хуваалцсан хүний тоо – 10, уншсан хүний тоо - 58

3. Аяны хүрээнд шинээр ажил санаачлан олон нийтэд сурталчлах

"Хувийн соёлоос нийтийн соёл, Нийтийн соёлоос хотын соёл" уриалгыг гарган байгууллагын цахим хуудсанд байршуулж иргэдийг уриалж байна. Цахим хуудаснаас мэдээллийг уншсан тоо - 16

Мөн дээрх уриалгаар тусгай фрем бэлтгэн фейсбүүк хуудсанд давалгаалуулах ажлыг зохион байгуулж байна.



ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН

МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА,
ХОТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ч.БАЯРЦЭЦЭГ

Ч.БАЯРЦЭЦЭГ